

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖИХ “БҮС НУТГИЙН АВТО ЗАМ ХӨГЖҮҮЛЭХ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН ТӨСӨЛ”

I. “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил”

Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн А0401, А0402, А0403 дугаартай улсын чанартай авто замууд нь Монгол улсын аж үйлдвэрийн томоохон төвүүд, газар тариалан, мал аж ахуй, эдийн засгийн гол бүс нутгийг дайран өнгөрдөг бөгөөд Алтанбулаг олон улсын худалдааны чөлөөт бүс, Улаанбаатар хотын ойролцоох дагуул хот, аялал жуулчлалын бааз, амралт сувиллын газруудыг нийслэл хоттой холбосон хөдөлгөөний эрчим ихтэй манай улсын гол авто зам юм.

Энэ чиглэлийн авто замаар нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим 2018 оны байдлаар хоногт дунджаар 5802 тээврийн хэрэгсэл, оргил ачааллын үе буюу наадмын өдрүүдээр хоногт дунджаар 12389 тээврийн хэрэгсэл зорчдог. Одоо байгаа авто зам нь 6,5 м зорчих хэсэг, 10 м өргөн далантай, IV ангиллын зам бөгөөд өнөөгийн эдийн засгийн хэрэгцээ, ачаа тээврийн өсөлт, авто тээврийн хөдөлгөөний эрчмийг хангаж чадахгүйд хүрсэн байна.

Иймд тус чиглэлийн авто замыг үе шаттайгаар өргөтгөн шинэчлэх зорилт тавин ажиллаж, эхний ээлжинд хамгийн их ачаалтай хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн 204,11 км IV ангиллын 2 эгнээ бүхий авто замыг I ангилал буюу 4 эгнээ болгохоор Монгол улсын Засгийн газрын 2018 оны 09 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлэсэн байна.


Эхний ээлжинд одоогийн байгаа 2 эгнээ авто замыг Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд өргөтгөн, шинэчлэхээр Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай 2018 оны 07 дугаар сарын 23-нд /МОН-3679/ 60 сая ам. долларын зээлийн гэрээг байгуулж, 2019 оны 03 дугаар сард нэмэлт 60 сая ам. долларын зээлийн хэлэлцээрийг хийсэн.



Баруун турууны даваа, 52-ын даваа, 60-ын даваа, Хараагийн даваа, Сэтэрхий хөтөл, Хустайн даваа гэх зэрэг газруудад налууг багасгаж, Баруун түрүүний даваа, 60-ын даваа, Тайсын хөтөл, Баянгол орчимд байх огцом эргэлтүүдийн радиусыг нэмэгдүүлсэнээр хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, үзэгдэх орчин сайжирна.

Авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийгдсэнээр 204,11 км асфальтобетон хучилтай, 11 м өргөнтэй 2 зорчих хэсэг бүхий 22 м өргөн авто зам болно.

Нийт дөрвөлжин хоолой 103 ширхэг, дугуй хоолой 155 ширхэг, 8 гүүр, авто зогсоолууд баригдана.



Улаанбаатар - Дархан чиглэлийн 204,11 км авто замын шинэчлэлтийн


барилгын ажлыг нийт 5 багц болгон хуваан шинэчилж өргөтгөхөөр ажиллаж байна.

- **1-р багц :**
Улаанбаатар хотоос Дархан болон баруун аймгуудын зам салдаг тойрог уулзвараас-Хар модотын (52-ын даваа)-ны ар хүртэлх 37,26 км
- **2-р багц :**
Хар модотын давааны араас-Тайсын хөтлийн өвөр хүртэлх 45,50 км
- **3-р багц :**
Урьхан зоогийн газрын орчмоос-Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын уулзвар 45,74 км
- **4-р багц :**
Бор толгой буюу Төв аймгийн Сүмбэр сум чиглэлийн авто замын уулзвараас-Цайдамын хөндий хүртэлх 45,05 км
- **5-р багц :**
Цайдамын хөндийгөөс Дархан хотын тойрог уулзвар хүртэлх 30,53 км

АВТО ЗАМЫН ХУЧИЛТЫН ХИЙЦ

Асфальтбетон хучилт	5 см
Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь	20 см
Цементээр бэхжүүлсэн хөрсөн суурь	20 см
Суурийн доод үе	30 см

Хөндлөн огтлолын зураг



Төслийн зам барилгын ажилд технологийн хяналт тавих Зөвлөхөөр Энэтхэг улсын “Intercontinental Consultants & Technocrats Pvt Ltd” шалгарч, 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.

Зам барилгын ажлын явц :

Багцын дугаар	Авто замын чиглэл, урт	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний үнийн дүн /ам.доллар/	Гэрээ хугацаа	Гүйцэтгэл /2020-05-20-ны байдлаар/
Багц 1-1	Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэлх 37.26 км авто зам	БНХАУ-ын “Хэйлонжиан Жиньей Рөүд энд Бридж”	13 064 749.90	2019.06.12-2020.06.30	47,87%
Багц 1-2	Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам	БНХАУ-ын “Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг” (групп)	13 777 743.90	2019.06.14-2020.06.30	9,49%
Багц 1-3	Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам	БНХАУ-ын “Гуйжоу Хайвэй Инженеринг Групп”	14 491 347.09	2019.06.14-2020.06.30	39,27%
Багц 1-4	Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто зам	БНХАУ-ын “Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг групп”	11 710 750.58	2019.06.14-2020.06.30	5,3%
Багц 1-5	Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 30.53 км авто зам	БНХАУ-ын “Чайна Жео-Инженеринг Корпораци”	9 834 336.56	2019.06.12-2020.06.30	33,43%
	Гэрээний нийт үнийн дүн		62 878 928.03		

II. “Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын засвар, арчлалтын ажил”

“Хүйтэний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын засвар, арчлалтын ажил”-ын олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтыг зарласан бөгөөд 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр тендерийг нээж, Үнэлгээний хороо ажиллаж байна.

III. “Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засвар, арчлалтын ажил”

“Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засвар, арчлалтын ажил”-ын сонгон шалгаруулалтыг 2020 оны 07 дугаар сард зарлахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө-17, Сүхбаатар дүүрэг 1-р хороо
“Гурван гол” оффис 404 тоот
И-мэйл: piu@rrtdm.org